

ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2022 оны 07 сарын 20 өдөр

Дугаар 80/2022

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Амгалан дулааны станц ТӨХК/ТӨБЗГ, эсхүл өмч эзэмшигч хуулийн этгээд/, түүнийг төлөөлж Ш.Баянмөнх (цаашид "худалдагч" гэх) нөгөө талаас Volkswagen touareg маркын автомашины дуудлагын худалдааны ялагч болсон иргэн /эсхүл хуулийн этгээд/ Б.Энхбаатар (нэр) УЮ70011715 (регистр, улсын бүртгэлийн дугаар) (цаашид "худалдан авагч", хамтад нь "талууд" гэх) нар дараах нөхцөлөөр харилцан тохиролцож Иргэний хуулийн 197 дугаар зүйлийн 197.2 дахь хэсэгт заасан дуудлагын худалдааны журмыг үндэслэн байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Гэрээний зорилго: Худалдагч гэрээнд заасан эрхийн зөрчилгүй Volkswagen touareg маркын жийп автомашин /эд хөрөнгийн нэр, марк төрөл/ (цаашид "эд хөрөнгө гэх" гэх)-ыг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх, худалдан авагч нь дуудлагын худалдааны журам, гэрээнд дурдсан нөхцөлөөр үнийг төлөхтэй холбоотой талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцпагыг зохицуулахад оршино.

1.2. Гэрээний зүйл: Худалдах, худалдан авах эд хөрөнгө Volkswagen touareg маркын жийп автомашин нь хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Герман улсад 2006 онд үйлдвэрлэсэн /нийт 16 жил ашигласан/, Volkswagen touareg маркийн, мөнгөлөг саарал өнгөтэй автомашин байна. Энд худалдах үеийн хөрөнгийн бодит байдал, техникийн болон шаардлагатай үзүүлэлтийг нэмж оруулна. *Шаардлагатай бол гэрээний зүйлийн үзүүлэлтийг тусгасан хавсралт үйлдэнэ.

1.3. Энэ гэрээ нь албан ёсоор байгуулагдсан өдрөөс эхлэн гэрээгээр хүлээсэн үүрэг бүрэн биелэх хүртэл хугацаанд үйлчилнэ.

Хоёр. Эд хөрөнгийг шилжүүлэх

2.1. Худалдан авагч Автомашины эд хөрөнгийн төлбөрийг гэрээнд заасны дагуу бүрэн төлснөөр өмчлөх эрхтэй болно.

2.2. Гэрээний зүйл нь эрхийн зөрчилгүй байна. Эрхийн зөрчилгүй гэдэгт гуравдагч этгээд өөрийн эдлэх эрхийн талаар ямарваа нэгэн гомдлын шаардлага гаргахгүй байхыг ойлгоно.

2.3. Худалдагч худалдсан эд хөрөнгийн холбогдох баримт бичгийг төлбөр бүрэн төлөгдөж гэрээнд заасан холбогдох дансанд орсноос хойш ажлын 5 өдрийн дотор эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг авч шилжүүлнэ. Эд хөрөнгийг эрх шилжүүлэх зөвшөөрөл гармагц хүлээлгэн өгнө. Хөрөнгө хүлээлцсэн актыг 2 хувь үйлдэж талууд тус бүр 1 хувийг авна.

2.4. Дуудлагаар худалдсан эд хөрөнгийн өмчлөх эрх шилжүүлэхтэй холбогдон гарах үйлчилгээний хураамж болон бусад зардлыг худалдан авагч хариуцна.

2.5. Худалдсан эд хөрөнгийг худалдан авагчид хүлээлгэн өгөхөөс өмнөх

хугацааны татвар хураамж, даатгалттай холбоотой зардлыг худалдагч бүрэн хариуцна.

Гурав. Төлбөр тооцоо

3.1. Энэхүү гэрээний 3.2-т заасан эд хөрөнгийн нийт үнэ **6,200,000.00** (тоогоор), **Зургаан сая хоёр зуун мянга** (үсгээр) төгрөг болно. Энэ нь эцсийн үнэ байна.

3.2. Энэхүү гэрээний 3.14 заасан үнэ нь дуудлагын худалдаанд оролцож ялсан үнэ болно.

3.3. Эд хөрөнгийн зах зээлийн үнэ, валютын ханш өөрчлөгдөх нь энэхүү гэрээний 3.1-д заасан үнийг өөрчлөх үндэслэл болохгүй.

3.4 Худалдан авагч нь дэнчин болгон нийт **1,500,000.00** (тоогоор) **Нэг сая таван зуун мянга** (үсгээр) төгрөгийг тушаасан бөгөөд дэнчин нь энэхүү гэрээний 3.3-д заасан үнэд тооцогдоно.

3.5. Худалдан авагч нь гэрээ албан ёсоор байгуулагдсанаас хойш 14 хоногийн дотор үлдэгдэл төлбөр болох **4,700,000.00** (тоогоор), **Дөрвөн сая долоон зуун мянга** (үсгээр) төгрөгийг худалдагч **Амгалан дулааны станц ТӨХК** (хуулийн этгээдийн нэр)-ийн, **Төрийн банк** (банк, дансны нэр) **106000036534** тоот дансанд шилжүүлнэ.

Дөрөв. Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг

4.1. Худалдагчийн эрх, үүрэг:

а) Худалдагч нь худалдан авагчид эрхийн доголдолгүй эд хөрөнгийг гэрээнд заасны дагуу хүлээлгэн өгөх үүрэгтэй.

б) Эд хөрөнгийн үнийг гэрээнд заасан хугацаанд төлөхийг худалдан авагчаас шаардах эрхтэй. в) Худалдан авагч худалдан авсан эд хөрөнгийн үлдэгдэл төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй бол дэнчинг улсын орлогод авч гэрээг дангаар цуцлах эрхтэй.

г) Гэрээний үүргээ бүрэн зохих ёсоор биелүүлэх үүрэгтэй.

4.2. Худалдан авагчийн эрх, үүрэг:

а) Гэрээнд заасны дагуу эрхийн доголдолгүй эд хөрөнгийг актаар хүлээн авах эрхтэй.

б) Эд хөрөнгийн үлдэгдэл төлбөрийг гэрээнд заасан хугацаанд бүрэн төлж барагдуулах үүрэгтэй.

в) Худалдан авсан эд хөрөнгийн үнийг бүрэн төлснөөр эд хөрөнгө, өмчлөх эрхийг шилжүүлэн авах болон холбогдох баримтыг шаардах эрхтэй.

г) Эд хөрөнгийг хүлээлцэхээр тогтоосон хугацаанд хүлээн аваагүй тохиолдолд тухайн эд хөрөнгийг хадгалах, хамгаалах, арчлахтай холбогдон гарах зардлыг нөхөн төлөх үүрэгтэй.

д) Гэрээний үүргээ бүрэн, зохих ёсоор биелүүлэх үүрэгтэй.

Тав. Талуудын хариуцлага

5.1. Энэ гэрээний нөхцөлийг зөрчсөн буруутай тал түүнээс болж нөгөө талд учирсан бүх хохирол, алдагдлыг үл маргалдах журмаар төлнө.

5.2. Худалдан авагч эд хөрөнгийн үнийг энэхүү гэрээнд заасан хугацаанд төлөөгүй бол худалдан авах эрхээ алдана.

5.3. Худалдан авагч эд хөрөнгийн үлдэгдэл төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй бол дэнчинг нэхэмжлэх эрхээ алдах ба энэхүү гэрээг худалдагчийн санаачилгаар цуцлах үндэслэл болно.

5.4. Худалдан авагч нь тогтоосон хугацаанд эд хөрөнгийг хүлээн аваагүй

тохиолдолд эд хөрөнгө хүлээлцэхээр тогтоосон өдрөөс хойшхи гэмтэл, доголдлыг худалдагч хариуцахгүй болно.

Зургаа. Маргааныг шийдвэрлэх

6.3 Талууд энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой үүссэн маргааныг харилцан тохиролцох замаар шийдвэрлэхийг эрхэмлэнэ.

6.2.Хэрэв харилцан тохиролцох боломжгүй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

Долоо. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл

7.3. Талууд гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүссэн эрсдэлийг бие даан хариуцах бөгөөд үүнтэй холбоотой аливаа асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

7.2. Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл (үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, зэвсэгт мөргөлдөөн, цэргийн эргэлт, террорист үйлдэл, иргэдийн үймээн, бослого, нийтийн эмх замбараагүй байдал)-ийн улмаас биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөлийг арилах хүртэл хойшлуулж болно.

7.3. Энэхүү гэрээний үүргийн биелэлтэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд нөгөө талдаа яаралтай мэдэгдэнэ.

7.4. Шаардлагатай бол төрийн эрх бүхий байгууллагын баримт нь гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл мөн байсан болон түүний үргэжилсэн хугацааны нотолгоо болно.


Найм. Бусад нөхцөл

8.1. Энэ гэрээ нь хавсралтын хамт нийт (.....) хуудас, үндсэн эхийг монгол хэл дээр 2 хувь үйлдэж, тал тус бүр 1 хувийг хадгална. Гэрээний эх хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.

8.2. Талууд энэ гэрээнд дурдаагүй бусад асуудлыг шийдвэрлэхэд холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгоно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:



ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Б.Энхбаатар
иргэн эсхүл хуулийн этгээдийн нэр
Гарын үсэг

Регистрийн дугаар: 6021646
Хаяг: Улаанбаатар хот Баянзүрх
Дүүрэг 8 дугаар хороо УС-15
Утас: 77111250
Факс: 77111253
И-мэйл хаяг: Amgalan.ahp@energy.mn

Регистрийн дугаар: УЮ70011715
Хаяг: Улаанбаатар хот Баянгол
дүүрэг 2 дугаар хороо ЭТӨҮгудамж 1-1
Утас: 95117917
Факс: _____
И-мэйл хаяг: _____